

14



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 64

Номгон

“Залуус” амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх тухай


Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотыг 2013-2033 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хамт батлагдсан “Залуус” амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь одоо байгаа гэр хорооллыг дахин төлөвлөлтөд хамруулан хэрэгжүүлэхээр байгаад өөрчлөлт оруулж Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын зүүн хэсгийн сул газарт “Залуус” амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгож оруулсугай.
2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэж хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ



0121348